

Манмин Мэдээ

Номер 29 2012 оны Арванхоёрдугаар сарын 2

Бурханы Хайр ба Ерөөл энэ газарт!

Сүм байгуулагдсаны 30 жилийн ойн баярын үйл ажиллагаа ба баярын тоглолт



30-н жилийн өмнө хүн төрөлхтөний авралын төлөө босгон байгуулагдаж, тэмдэг гайхамшиг болон Бурханы эрх мэдэлт хүчээр үй олон хүмүүсийг авран, библи дээрхи анхны цуглаан мэт өнөөг хүртэл давшин манай төв сүм 2012 оны Аравдугаар сарын 7-нд, 30 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлэлээ. Маш үзэсгэлэнтэй засаж, чимэглэсэн тайз, болон өндөр түвшинд бэлтгэгдсэн урлагын тоглолтууд лазер гэрэлтүүлэг зэрэг тусгайлан засаж бэлдсэн үзүүлбэрүүд бүхий баярын тоглолтыг GCN TV болон интернэтээр шууд дамжуулж дэлхийн өнцөг булан бүрт байх салбар сүмүүд нь хамтдаа энэ сэтгэл хөдлөл тоглолтыг үзэж байлаа. ■ Зураг 1: Манмин төв сүмийн тэргүүн пастор Доктор И Жейруг ■ Зураг 2: Баярын үг хэлж буй NRB христийн хэвлэл мэдээллийн албаны захирал Доктор Франк Брайт ■ Зураг 3: “Тэнгэр ба Газар” хэмээх сэдэвт урлагын тоглолт ■ Зураг 4: Гадаа байрлуулсан зурагын авахуулах газар ■ Зураг 5-7: Баярын өмнөх үйл ажиллагааны тоглолтуудын зургууд, “Бурхандаа Алдар”

Өнгөрөгч Аравдугаар сарын 7-нд Манмин Төв Сүм дэлхий даяарх 10 мянга гаруй салбар сүмүүдтэйгээ хамт 30 жилийн ойн баяраа тэмдэглэн, баярын тоглолтоор Бурхандаа бүх талрахал ба алдрыг өргөв.

Ням гаригийн Хүндэтгэлийн цуглааны үйл ажиллагаан дээр Доктор И Жейруг тэргүүн пастор Исаиа 60:1-3-д ишлэлээр “Бурханы хайрладаг сүм: Тэнгэр” хэмээх сэдэвт сургаал айлдахдаа “Бурхан өнгөрсөн 30 жилийн турш энэ сүмд тэнгэрийг өөрөөр хэлбэл сүнслэг ертөнцийг үзүүлж өгөн амийн үг сургаал ба Бурханы эрх мэдэлт хүч чадал, Тэнгэрийн орны үзэсгэлэнтэй байдлыг дүрсэлж буй өндөр түвшний магтаал дууны болон урлагын тоглолтуудаар дамжуулан Бурханы агуу хайрыг илэрхий болгож өгсөн билээ” хэмээн айлдсан юм.

Үдээс хойшхи мөргөлөөр мөн Исаиа 60:1-3 ишлэлээр “Бурханы хайрладаг сүм: Газар” хэмээх сэдвээр “Газар болох энэ дэлхий

дээр амьдарч буй бидэнд тэнгэрт болдог агуу гайхамшигт зүйлсийг үзүүлдэг нь сорилтоор дамжуулан ариун байдлыг олмогцоо Бурханыг дуурайсан сүнсний хүн болж өөрчлөгдөхийн төлөө юм” хэмээн дурдсан билээ.

Үйл ажиллагааны үеэр NRB (Дэлхийн Христийн нэвтрүүлгийн нэгдсэн холбоо)-ны захирал Доктор Франк Врайт мэндчилж үг хэлсэн юм. Тэрээр хэлэхдээ “Өнөө үед маш олон сүмүүд Есүс Христийн сайн мэдээг тунхаглахаасаа айх болон эргэлзэж байгаа энэ үед Манмин төв сүм нь Бурханы эрх мэдэлт хүчээр дамжуулан маш эрч хүчтэй, зоригтойгоор Есүс Христийн нэрийг бүх дэлхийгээр тунхаглаж буй маш онцгой цуглаан юм” гэж онцлон тэмдэглэв.

Христийн сайн мэдээ ба сэргэлтийн холбооны ерөнхийлөгч И Жонман пасторын адислалаар баярын цуглаан өндөрлөж, “Тэнгэр ба газар” гэсэн нэрээр баярын тоглолт эхлэв. Сүмийн магтаал дуу

бүжгийн багийнхан 30 жилийн ойн баярын үйл ажиллагааг хүртэл Манмин сүмийг удирдсаар ирсэн Бурханы хайрыг, тэнгэрлэг дайчид ба тэнгэрийн элч нар болон энэ газар дээр дасгалжуулагдаж буй итгэгч нарын зүрх сэтгэлийн анхилуун үнэрийг агуулан Бурхандаа алдрыг өргөж буй дүр төрхийг Бурханы Өөрөө өгсөн дуунуудаар илэрхийлсэн юм. Энэ тоглолтонд ойролцоогоор 500 гаруй хүмүүс оролцсон ба 60 минутын турш үргэлжилсэн гайхамшигтай тоглолт болж өнгөрсөн юм (Дэлгэрэнгүйг 4-р хуудаснаас үзнэ үү).

Мөн Болгар улсаас ирсэн Доктор Кирил Свиленов энэ тоглолтын тухай “Би энэ гайхамшигт тоглолтыг үзээд үнэхээр их сэтгэл хөдөллөө. Бурханы оршихуй хамтдаа байгааг би мэдэрсэн юм” хэмээн хэлэв. Сингапураас ирсэн Ви мари пастор “Тэнгэрийн орны үзэсгэлэнтэй байдлыг мэдэрч мөн их хүсэн тэмүүлж байна. Ингэж тэнгэрийн орныг мэдрүүлж өгдөг энэ тоглолт дэлхий даяар түгээгдэх болтугай”

хэмээв.

Энэ тоглолтыг үзсэн итгэгчид ариухан үзэсгэлэнтэй тэнгэрийн орны байдлыг мэдэрч, Шинэ Иерусалимд Ариун гурвын Бурхантай хамт мөнхөд хамтдаа байхын тулд илүү хурдан ариун байдлыг биелүүлэх хүсэл эрмэлзэлийг бий болгов.

Энэ өдөр Хүндэтгэлийн цуглаан болон үдээс хойш цуглаанд Солонгос болон гадаадын Христийн хэвлэл мэдээллийн сурвалжлагчид нар болон улс төрийн зүтгэлтэнүүд болон WCDN (Дэлхийн Христэч Эмч нарын сүлжээ)-ний эмч нар болон АНУ, Хятад, Энэтхэг, Герман болон Перу улсаас гадаадын зочдоор дүүрэн байлаа. Гадаа сүмийн талбай дээр олон төрлийн хоол унд бэлдсэн байсан ба сүмийн гишүүд болон зочид гийчдэд зориулсан фото зураг авах газруудыг бэлдсэн нь гаргасан байсан нь баяр дээр улам баяр нэмсэн гайхалтай зүйл болсон байлаа.

Түүнчлэн 2012 оны Аравдугаар сарын 5-нд болсон Баасан

гаригын Оройн цуглаан дээр сүм байгуулагдахаас эхлэн зөвхөн Бурханы удирдлага дотор асар хурдацтай өссөн манай төв сүмийн 30 жилийн түүхийг харуулсан Манмин мегазин хөтөлбөрөөр “Итгэлээрээ явж ирсэн зам” баримтат кино үзүүлсэн ба уг оройн цуглааны 2-р хэсгээр магтаал дуу бүжгийн багын бэлтгэсэн “Бурханы алдар” гэсэн тусгай тоглолтыг толилуулсан юм. Оройн цуглаан өмнө тусгайлан зассан тайзан дээр хүүхдийн багынхан тусгай үзүүлбэр үзүүлсэн нь олны талархалыг маш ихээр татав.

Доктор И Жей руг тэргүүн пастор нь ойн баярын өмнөх энэ үйл ажиллагаанд “2012 оны Долдугаар сард сүм эхэлсэн 30 жилийн ойн тэмдэглэлт өдөр байсан үүний тэмдэглэлт өдөр хүртэхэд бэлтгэх цаг байсан ба энэ удаагийн ойн баяраар сүм болон итгэгчидэд ерөөл бууж эхлэх болно” гэж айлдсаны дараа ажил албандаа том ерөөл хүртсэн итгэгчдийн гэрчлэл үүнийг бататгаж өгч байлаа.

Галт могой ба Загалмай

“Тэгтэл ЭЗЭН Мосед-Галт могой хийж, түүнийг шургаагны оройд байрлуулагтун. Тэгвэл хатгуулсан хүн бүр түүнийг хараад амьдрах болно гэв. Мосе хүрэл могойг хийж, түүнийг шургаагны оройд байрлуулав. Хэрвээ хэн нэгэн хүнийг могой хатгасан байвал, тэр хүн хүрэл могойг хараад амьдарч байлаа” (Тооллого 21:8-9).
 “Мосе цөлд тэр могойг өргөсөн шиг, Хүний Хүү ч бас өргөгдөх ёстой. Энэ нь Түүнд итгэгч хүн бүрийг мөнх амьтай байлгахын тулд билээ” (Иохан 3:14-15).



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

Энэ удаад Израйлын ард түмэн халуун шатам элсэн цөлд тохиолдсон галт могойн үйл явдлаар дамжуулан бидний ухаарах ёстой зүйл болон Есүсийн загалмайтай ямар холбоотой болохыг үзмэгцээ “Загалмай үг” сургаалыг өндөрлөө.

1. Бурхан болон Мосегийн эсрэг гомдоллосон учир галт могойд хатгуулсан Израйлийн ард түмэн.

Тооллогын 21-р бүлэг дээр дурдсан үйл явдал нь Израйльчууд Египетээс гарсаны дараа тохиолдсон зүйл юм. Египетэд 400 гаруй жилийн турш боолчлогдон амьдарч байсан тэд Бурханд хандан өөрсдийг нь аварч өгөөч хэмээн гуйсаар байсан билээ. Бурхан тэдний залбирлыг сонсч Мосег илгээн гайхамшигт хүчүүдийг үйлдэн, Израйлийн ард түмнийг Египетийн боолчлолоос чөлөөлж өгсөн билээ.

Израйльчууд Египетээс гарсаны дараа шууд л “сүү, бал бурам бялхсан үржил шимт Канаан газарт очих байх” хэмээн төсөөлөн найдаж, байсан боловч тэдний хүссэнээр болоогүй төдийгүй тэдний нөхцөл байдал өөр байсан юм. Бурхан Израйльчуудыг ерөөлийн газар руу орох болзолыг хангуулахын тулд цөлийн амьдралаар дасгалжуулж байсан боловч тэд үүнийг ухааралгүйгээр хүнд хэцүү зүйлтэй тулгарах болгондоо гомдоллон тавгүйтэж байсан юм. Эцэст нь тэд өөрсдийн итгэлээрээ үйлдэж чадаагүйн улмаас 40-н жилийн турш цөлд соригддог билээ.

Египетийн боолчлолоос чөлөөлж өгсөн ч гэсэн тэд өөрсдийг нь цөлд үхүүлэхээр авчирлаа гэж, мөн Бурханы тэдэнд буулгаж өгсөн маннаг “Бид энэ заваан хүнсийг жигшиж байна” (Тооллого 21:5) гэх мэт Бурхан болон Мосед гомдоллж байсан билээ. Үүний улмаас Бурхан хилэн буухад үхлийн хорыг агуулсан галт могойнуудад маш олон Израйльчууд хатгуулан үхдэг билээ.

Тэр үед л Израйльчууд Мосе дээр очин өөрсдийн гэм нүглийг өчин гэмшихэд Мосе тэдний төлөө залбирал үйлдэхэд Бурхан тэдэнд амьдрах аргыг зааж өгөн, хүрлээр могой хийж шургаагны үзүүрт байрлуулахад могойд хатгуулсан хүмүүс тэр хүрэл могойг харсан хүн болгон аврагдах тухай айлдсан билээ.

2. Галт могойн үйл явдлаар дамжуулан бидний ухаарах ёстой сүнс зүгийн сургамж

1) Бидэнд ямар ч хүнд асуудал байсан Бурханы шийдвэрлүүлэх хэрэгтэй.

Бурхан бол үхэл амьдралыг удирддаг, бүхий л түмэн бодис ба бүх бүтээлийг хөтлөн жолооддог төгс хүчит Эрхэм тул галт могойг ирүүлэх болон энэ гай гамшигаас хүртэл аварч өгдөг. Энэ нь огт байхгүй байсан галт могойнууд гэнэт гарч ирсэн зүйл огт биш юм. Энэ мэт халуун цөлд угаасаа хорт могой болон хилэнцэт хорхой маш элбэг байдаг боловч Бурхан тэд нарыг хамгаалж байсан учир хорт могойнууд ойртож чаддаггүй байсан билээ. Гэтэл Израйльчууд Бурханд гомдоллон, Түүний эсрэг ярих үед Бурханы хамгаалалт байхгүй болж хорт могойнууд нэвтрэн орж хохирол учруулсан билээ.

Тиймээс, Израйльчууд галт могойнуудын дайралтанд өртөх болсон шалтгаан болон үүнийг шийдвэрлэхийн тулд Бурханы тусламжыг хайдаг билээ. Үүний адил, хүмүүсийн энд дэлхий дээр тохиолддог бүхий л асуудлуудыг ч мөн Бурханы өмнө шийдвэрлүүлэх хэрэгтэй юм. Энд галт могой нь дайсан болох муу ёрын сүнс сатаныг дурдан хэлж байгаа бөгөөд Эхлэл номын 3:14-д эмэгтэйг мэхэлсэн могойд “Насан туршдаа тоос шороо идэх болно” хэмээн айлдсан ба тоос шороо гэдэг нь тоос шорооноос бүтээгдсэн амьд оршигч хүн гэм үйлдэн махан бие болсон Адам болон түүний үр удмыг хэлж байгаа юм. Адам гэм нүгэл үйлдсэнээс хойш могой буюу дайсан сатан нь гэм нүгэл дотор амьдарч буй махан биенийн хүмүүсийг хоолоо болгон үргэлж гай зовлон, өвчин, хүнд хэцүү зүйлүүд рүү хөтөлдөг.

Дэлхий хүмүүс нь элдэв осол аварь, өвчин хүнд хэцүү зүйл тохиолдвол өөрийн хувь тавилан эсвэл санамсаргүй тохиолдсон зүйл хэмээн боддог бол Бурханы хүүхдүүд нь асуудлыг уг шалтгааныг ухааран асуудлаа шийдвэрлэх боломжтой байдаг (ИИохан 5:18). Израйлийн ард түмэн өөрсдийн гэм нүглийг ухааран гэмшихээр Мосе дээр ирсэн шиг бид ч мөн өөрсдийн гэм нүглээ ухааран Бурханы өмнө гэмшин ирэх хэрэгтэй байдаг. Хэн ч гэсэн чин сэтгэлээсээ гэмшин гэмийн ханыг нураан, гэрэл дотор гарч ирвэл Бурхан ямар ч асуудлыг сайнаар шийдэж өгдөг билээ.

2) Итгэлийн сорилтыг зөвхөн баяр хөөр ба талархалтайгаар туулан хэрэгтэй

Бурхан Өөрийн үр хүүхдүүддээ сорилтыг зөвшөөрсөнөөр үүгээр дамжуулан итгэл нь батжин шижир алт мэт итгэлтэй болохоос гадна ерөөл хүртэх зохистой аягыг бэлдүүлж өгдөг билээ (Иаков 1:4). Итгэлийн өвөг дээдсүүд ч гэсэн Бурханы амласан ерөөл хүртэх хүртэл удаан хугацааны турш янз бүрийн хүнд хэцүү сорилтын цагыг туулан өнгөрүүлдэг.

Израйлийн ард түмэн цөлд соригдох нь хүртэл эцэстээ энэ нь ерөөлийн газар Канаан нутгыг

олохын тулд байсан билээ (Дэд хууль 8:15-16). Тэд Бурханд итгэж, түшиглэн найдсан бол гомдоллохын оронд ерөөл өгөх Бурханы хайранд талархан, өөрсдийгөө өөрчлөх ёстой юм.

Бид талархал ба баяр хөөртэйгөө сорилтыг сайн туулах юм бол заавал амлалтын газар Канаан нутаг руу орох боломжтой. Сорилтон дунд байхдаа ч ерөөл хүртэх зохистой зүрх сэтгэлийг бэлдэн, сорилтыг даван туулан, итгэлээ харуулах үед Бурхан ерөөж өгөхөд муу ёрын сүнс сатан ч биднийг буруутгаж чадахгүй байх билээ.

Харин гоморхол, тавгүйтэх юм бол ерөөл хойшилж, сорилтын хугацаа сунах төдий ба талархаж чадахгүй байна гэдэг утгаараа итгэлгүйн шинж бөгөөд ерөөл хүртэх болоогүйн баталгаа болдог билээ.

3) Хүрэл могойг харан итгэлтэй болгосон Бурханы хайрыг ухаарах хэрэгтэй.

Израйлийн ард түмэн галт могойнд хатгуулах тэр үед шургаагны үзүүрт бэхэлсэн хүрэл могойн дүрсийг харж байж л амьдрах, эдгэрэх боломжтой байлаа. Энэ нь тэгвэл Бурхан хүрэл могойг харуулалгүй эрх мэдэлт хүчээр эдгээр чадахгүй байсан гэсэн үг үү? Хэрэв Израйлын ард түмэн Матай 8-р бүлэг дээр гардаг зуутын дарга мэт итгэлтэй “үгээ айлдаач” гэсэн шиг итгэл байсан бол “эдгэр” хэмээн айлдахад л болох байсан билээ (Матай 8:8).

Гэвч, Израйльчуудад ийм бүрэн дүүрэн итгэл байхгүй байв. Бурханы хүч чадал хичнээн агуу ч гэсэн итгэлгүй хүмүүст ямар ч үр дүнгүй тул итгэхийн тулд тэдний нүдэнд харагдах итгэлийн тэмдэгийг өгсөн юм. Өөрсдийг нь хордуулж буй галт могойн дүрсийг шургаагны үзүүрт бэхэлж, түүнийг харах үед Бурхан галт могой гамшигаас аварч байгааг маш тодорхой байдлаар тэдний зүрх сэтгэлдээ итгэх боломжтой учраас тэр билээ.

Иохан 4:48-д, “Есүс- Хүмүүс та нар хэрэв тэмдэг, гайхамшигуудыг үзэхгүй бол ер итгэхгүй гэж айлдав” хэмээн дурдсанчлан бүтээгч Бурхан ба Аврагч Эзэн Есүс Христэд итгээрэй хэмээн тунхаглалаа ч хатуу сэтгэлтэй хүмүүс итгээ гэдэггүйг харж болно. Харин ч Бурханд итгэдэг хүмүүс ч гэсэн дэлхийн зугаа цэнгэлд автан, сургаалийн дагуу амьдарч чадахгүй тохиолдол их байдаг билээ. Гэхдээ хүний хувьд боломжгүй зүйл эрх мэдэлт хүчний үйлсийг харж, сонсож, биеэр үзэж мэдэрвэл үл итгэгч хүн ч Бурханыг хүлээн зөвшөөрч итгэгч нар ч жинхэнэ итгэлтэй болж, сургаалийг дагуу амьдрах боломжтой болдог.

3. Шургаагны үзүүрт бэхэлсэн хүрэл могойг харан аврал хүртэх боломжыг өгсөн Бурхан

Иохан 3:14-15-д, “Мосе цөлд тэр могойг өргөсөн шиг, Хүний Хүү ч бас өргөгдөх ёстой. Энэ нь Түүнд итгэгч хүн бүрийг мөнх амьтай байлгахын тулд билээ” хэмээн айлдсан байдаг ба энэ нь Есүсийг загалмайд цовдлох тухай дурдсан байдаг. Гэм нүгэлгүй Есүс бидний гэм нүглийн төлөө галт могойг шургаагны үзүүрт өлгөдөг шиг загалмайд цовдлогдсон билээ.

Тэгвэл могой нь сатан гэсэн утгатай ба шургаагны үзүүрт буй могойг харах болон загалмайд цовдлогдсон Есүсийг харах нь яагаад адил гэж байгаа юм бол? Энэ нь нь муу ёрын сүнс сатаны мөхлийг илэрхийлж байгаа учраас тэр юм. Бид загалмайд цовдлогдсон Есүсийг харна гэдэг нь муу ёрын сүнс, сатаны үхлийн хүч бутран унаж буйг итгэлийн нүдээр хардаг учраас түүнд итгэх үед мөнх амийг авах боломжтой болдог билээ.

Сүнслэг ертөнцийн хуулинд нүглийн хөлс нь үхэл бөгөөд Адамын гэмт үйлдлээс хойш Адам гэмтэн болж түүний үр удам ч бүгд үхлийн шийтгэл авах болсон билээ. Өөрөөр хэлбэл муу ёрын сүнс сатаны эрх мэдэл дор төрөл бүрийн сорилт, хүнд хэцүү асуудал дотор амьдарсаар үхвэл там руу илгээгдэн үүрд мөнх шийтгэгдэх болсон байдаг билээ.

Ийм хүн төрөлхтөнийг аврахын төлөө Есүс энэ газар дээр буун ирэхэд муу ёрын сүнс сатан атгаг хүмүүсээр дамжуулан ямар ч гэм нүгэлгүй Есүсийг загалмайд цовдолж алсан юм. Гэвч сүнслэг ертөнцийн хуулиар үхлийн шийтгэл нь гэм нүгэл хийсэн хүмүүст л ирэх зүйл байсан боловч муу ёрын сүнслэг ертөнцийн хуулийг зөрчин ямар ч гэм нүгэлгүй Есүсийг алснаараа тэдний үхлийг захирах хүч нь хураагдсан билээ.

Тийм учраас Есүсийг өөрийн Аврагч Эзэн гэж хүлээн авч итгэсэн хүмүүсийг сатан өөрийн эрхшээлээс гаргаж тавихаас өөр аргагүй болсон юм. Тиймд загалмайд цовдлогдсон Есүс Христийг өөрийн Аврагч хэмээн хүлээн зөвшөөрч итгэдэг хэн ч Эзэний нэрэнд итгэн, залбирахад бүх сорилт хүнд хэцүү байдлуудаас ангижрах боломжтой болсон юм.

Израйлийн ард түмэн дуулгавартайгаар шургаагны үзүүрт бэхэлсэн хүрэл могойг харан амьдарч байсан ч хатуу сэтгэлтэй дуулгаваргүй хүмүүс галт могойн хорны улмаас үхэжээсэн билээ. Үүний адил, өнөө үед ч Есүс Христийг хүлээн зөвшөөрвөл авралыг хүртэх ч гэсэн Түүнд итгэдэггүй хүмүүс нь аврал авч чадалгүй там руу явах болно гэдэг нь туйлын үнэн билээ.

Хайрт итгэгч та бүхэн, хүн төрөлхтөнийг аврахын тулд хайртай цор ганц Хүүгээ өгсөн тэр хайранд талархан, маш хурдан Эзэнийг дуурайсан энэ газар дээр ч ерөөл хүртэн, тэнгэрийн оронд мөнхөд алдар сүр жавхлан дотор байхыг Эзэний нэрээр хүсэн өрөөе!

Mongolian

Манмин Мэдээ


Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
e-mail: manminministry@hotmail.com
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин

Монгол Манмин Төв Сүм

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С

Утас: чуулганы- 5525-7637
чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.manmintv.org

“Манмин Төв Сүмтэй уулзана гэдэг миний амьдралд тохиолдсон гайхамшигт ерөөл”



Анхны сүмийн үзэсгэлэнтэй байдлыг дуурайсан гайхамшигт сэргэлт ба өсөлт хөгжлөөр Бурхандаа алдрыг өргөж буй Манмин Төв Сүм. Манмин сүмийн тэргүүн пастор Доктор И Жей руг пастораар дамжуулан гарч буй Манминий үйл ажиллагааг үзэхийн тулд гадаадаас олон хүмүүс манай төв сүмд зочилсон юм. Манмин сүмийн 30 жилийн ойн баярын үйл ажиллагаанд оролцсоны дараа Мүан Манмин цуглаанд мөн зочлон очсон эдгээр хүмүүсийн ивээл дүүрэн гэрчлэлүүдийг та бүхэн толилуулъя.



| Болгар | Иван Хазарбассанов пастор

“Доктор И Жейруг пастор маш даруу хүн боловч түүний сургаа нь үнэхээр хүчирхэг санагдлаа.”

Би Болгараас ирсэн пастор бөгөөд одоогын байдлаар нийт 15 сүмтэй хамтран ажилладаг билээ. 2011 онд Австрали улсад болсон WCDN (Дэлхийн Христэд итгэгч эмч нарын сүлжээ) ДХЭС 8-р чуулга уулзалтанд оролцож буй эм зүйч мэргэжилтэй манай цуглааны итгэгчээр дамжуулан Манмин сүмийн тухай олж мэдэж авсан.

Энэ удаад Бурханы гайхамшигт хүчийг хүсэн тэмүүлсээр Манмин төв сүмд анх удаа ирж байгаа билээ. Сүмийн итгэгчид чин сэтгэлээсээ Бурханд үйлчлэн өдөр бүр залбирдаг болохыг хараад би маш их сэтгэл хөдлөл ба ивээлийг хүртсэн билээ.

Мөн Доктор И Жей руг тэргүүн пастор маш төлөв даруу бөгөөд агуу өргөн сэтгэлээр олон хүмүүсийг хайрлаж үйлчилдэг эрхэм байлаа. Түүний сургаал нь гайхамшигт хүчтэй ба Христчин хүмүүст маш хэрэгтэй итгэлийн амьдралын үндэс суурийг талаар зааж сургасан юм.

Их сургуульд хөгжмийн чиглэлээр сурдаг миний эхнэр ялангуяа 30 жилийн ойн баярын тоглолтоор дамжуулан үгээр илэрхийлэхийн аргагүй ивээл хүртсэн бөгөөд Тэнгэрийн оронд ирсэн мэт гайхамшигтай чадварлаг тоглолт болсон юм.

Сүмд оркестрийн хэмжээний хөгжимчдийг цуглуулж тоглуулна гэдэг амар ажил биш бөгөөд Манмин төв сүмийн Нисси Оркестер нь сэтгэлд үнэхээр их таалагдсан юм. Манай эхнэр сүмдээ хөгжмийн хэсгийг хариуцдаг ба тоглолтоор дамжуулан Бурханы хайр ба Түүний оршихуйг мэдэрч нулимс дуслуулан үзэж байлаа.

Бидэнд ерөөл өгдөг маш сайхан аялгуут магтаал дуу болон бүжгээр Бурхандаа алдрыг өргөе хэмээн шийдсэн билээ. Сүмийнхээ залуучууд хүүхдүүдэд энэ тоглолтыг үзүүлэн, Бурханы баярлан таалдаг магтаал гэж юу болох заах бодолтой байна.



| Индонез | Елли Танувижаяа пастор

“Тэнгэрийн оронд байгаа мэт аз жаргал ба баяр баясгалангаар дүүрэн.”



Долоон жилийн өмнө манай сүмийн нэгэн итгэгч бидэнд Доктор И Жей руг пасторын “Тэнгэрийн орон” ба “Там” гэсэн номнуудыг өгснөөр түүний мэддэг болсон юм. Тэдгээр номуудыг уншсаны дараа бид амьдралын тухай ойлголт маш их өөрчлөгдөн энэ номд бичигдсэн зүйлсүүдийг бусдад дамжуулж байгаа билээ. Мөн “Манмин Мэдээ” индонез хэл дээрх сонинг ойр хавийнхаа хүмүүст тараан түгээдэг. Сонингоор дамжуулан маш олон хүмүүс ивээл авч “Өнөө үед ийм гайхамшигт зүйлс тохиолддог сүм байдаг байхнээ” хэмээн баярлан дурдацгааж байдаг.

Би миний нөхөр болох Лухут пасторын хариуцдаг Сайн мэдээ цуглааны дэд пастор билээ. Одоогоос хоёр жилийн өмнө буюу 2010 онд манай нөхөр Манмин төв сүмийн төв танхимын индэр ард байрлах Эзэн дахин ирж буй зургыг хараад архаг астма өвчнөөсөө бүрэн эдгэрсэн юм.

Мөн Доктор И Жей руг пастораас залбирал авсан эрх мэдэлт хүчит гар алчуураар (Үйлс 19:11-12) сүмийнхээ итгэгч нарт залбирал хийж өгөхөд төрөл бүрийн өвчнөөсөө эдгэрч байгааг хараад маш их аз жаргалтай байна. Түүнчлэн “Эрх мэдэлт хүч” DVD видео бичлэгээр дамжуулан, мөн Доктор И Жей руг пасторын өвчин эдгээх залбирал ч мөн итгэгч нарын асуудлууд шийдэгдэж, төрөл бүрийн өвчнөөсөө эдгэрсээр байгаа билээ.



Манмин төв сүмийг олж мэдэж авсан нь миний амьдралд тохиолдсон гайхамшигт ерөөл

| Япон | Яамане Киуоко итгэгч

“Мүан амтат усны хүрээлэнд сүнсний ертөнцийг мэдэрсэн юм.”

ба аз жаргалтай зүйл юм. Итгэгчдийн хайр, Тэнгэрийн орныг мэдрүүлэх мэт тоглолтууд зэрэг эдгээрээр дамжуулан үнэхээр аз жаргалтай байгаа бөгөөд энэ бүгдийг үгээр илэрхийлж чадахгүй байна. Ялангуяа Доктор И Жей руг пасторын залбиралаар далай шорвог ус нь цэнгэг амтат ус болон хувирсан Мүан амтат усны хүрээлэнд

| АНУ | Доктор Сергей Мартинук итгэгч

“Бурханы хайр болон Эзэний ивээл дүүрэн өдрүүд байлаа.”



Олон хүмүүс Эзэнд итгэдэг гэдэг ч ихэнх нь яаж итгэлээ өсгөх талаар, мөн илүү сайхан тэнгэрийн оронд орохын тулд мөн төгс авралд хүрэх талаар мэдэхгүй байдаг.

Тиймээс дэлхийн зүйлтэй хутгалдан итгэлийн амьдралаар амьдрах нь элбэг тохиолддог. Хэдий тийм ч гэсэн Доктор И Жей руг пастор нь бидэнд итгэлийн амьдралаар хэрхэн амьдрах болон тэнгэрийн орны тухай “Итгэлийн хэмжээ” гэх мэт номоор дамжуулан мэдүүлж өгч байгаа хүсэл тэмүүлэл дотор амьдрах боломжтой болдог.

Би Манмин төв сүмийг И Жей руг пасторын удирдсан “2006 оны Нью Йорк-н нэгдсэн их цуглаан” хийхээс өмнөхөн л олж мэдэж авсан юм. Тухайн үед би нэгдсэн их цуглааны бэлтгэл ажлаар ирсэн Ким Жин хүн ахлагчтай уулзан гар алчуурын залбирал авч, барууг хөлний үрэвсэл өвчнөөсөө эдгэрсэн билээ.

Түүний дараа “2006 оны Нью Йорк-н нэгдсэн их цуглаан” д оролцож Доктор И Жей руг пастораар дамжуулан гарч буй Бурханы хүч чадлыг хармагцаа миний итгэл шинэчлэгдсэн юм.

Түүний дараа “Загалмайн Үг” зэрэг сургаалиудыг сонсоод аз жаргалтай итгэлийн амьдралаар амьдрах болсон юм.

Манмин төв Сүм дээр айлчлан очсон өдрүүдэд Бурханы хайр болон Эзэний ивээлээр дүүрэн цаг мөчүүд байлаа. Итгэгч нараас нь жинхэнэ итгэлийн дүр төрхийг харж, Доктор И Жей руг пасторын залбирлыг авмагцаа чин сэтгэлээсээ хүмүүсийг хайрладаг жинхэнэ хоньчин болохыг ухааран сэтгэл хөдөлж байлаа.

Бурханаас өгсөн магтаал дуу ба бүжиг, тоглолт болон 30 жилийн Ойн баярын тоглолтуудыг үзэн тэнгэр орны тэмүүлэл минь улам их нэмэгдсэн билээ.

Мөн түүнчлэн, мододын дунд зогсож буй эш үзүүлэгч нарын төрх, болон Ариун Сүнсний сэлэм, алтан өнгөтэй эрдэнэсээр чимсэн шатыг би харсан билээ. Нарны эргэн тойронд сургаал үгийн сэлэм дүүрэн байгааг харж, хөх ногоон өнгөтэй болон олон өнгийн гэрэл цацруулсан алтлаг өнгөтэй модыг олж харав. Эдгээр зүйлээр дамжуулан Сүнслэг ертөнцийг бодитоор оршин талаар баттай мэддэг болж, тэнгэрийн оронд улам их тэмүүлж байна. Энэ төдийгүй Мүан амтат усанд 7 удаа булхсаны дараа мөр хөшин өвддөг байсан өвчин болон нүд болон хөлний өвчнөөсөө эдгэрсэн билээ.

ЭХЛЭЛ

Үйл ажиллагааны эхэнд “Эхлэл” хэсэг нь Бурханы агуу хүсэл төлөвлөгөөг илэрхийлсэн аязаар эхлэн энэ аяыг даган бүжих тэнгэр элч нарын бүжиг наадах уяхан хөдөлгөөний дараа сүр жавхланг илэрхийлсэн хүчит дуулалууд, ба элч нарын жагсаал болон баярын тоглолтыг илтгэх мэт сэтгэл хөдлөм аяз.




Сүм байгуулагдсаны 30 жилийн ойн баярын тоглолт

“ТЭНГЭР ба ГАЗАР”



ТЭНГЭР

Манмины 30 жилийн ойн баярт үйл ажиллагаанд баяр хүргэх тэргүүн тэнгэр элч ба тэнгэр элч нарын бүжиг ба магтаалаар дүүрэн Бурхан Аавын хайрын сэтгэлийг илэрхийлэн.



ГАЗАР

Энэ газар дээр дасгалжуулагдаж буй Бурханы үр хүүхдүүд агаар мандал дахь хурим найр ба олон нийтийн баяр наадмын уур амьсгалаар Бурхан Аавдаа бүжиг болон магтаалын өргөн барьж байгааг илэрхийлэн өндөрлөж хамгийн сүүлд бүх итгэгчид хамтдаа Бурхандаа баярт магтаал дууг өргөн барив.



Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь

залбирал цагийн хуваарь

Мөргөл	Цаг	Ангилал	Цаг	Удирдагч
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30	Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30			
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00	Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30			
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00	Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00			
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00			

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:

Г. Анхбаяр СМТ 976-91173712
976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com